

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН /ОРОН НУТГИЙН ТӨСӨВ/ 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: ХӨА-2022/249/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас

https://audit.mn/?page_id=579

Хөвсгөл аймаг

Мөрөн сум

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 99900662 Цахим хаяг: Baterdenee@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран

Утас: 92118277 Цахим хаяг: MandakhnaranL@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	5
3. Аудитын тайлан.....	6
3.1 Ерөнхий зүйл.....	6
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	6
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	6
3.4 Материаллаг байдал.....	7
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	7
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	7
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	8
3.8 Аудитын гол асуудал.....	8
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	8
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	8
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	9
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	9
4. Аудитын илрүүлэлт.....	9
4.1 Залруулсан алдаа.....	9
4.2 Төлбөрийн акт.....	9
4.3 Албан шаардлага.....	9
4.4 Зөвлөмж.....	9



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.18 № 01/32
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Б.ЭРДЭНЭХУЯГ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Халамжийн сангийн /орон нутгийн төсөв/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Халамжийн сангийн /орон нутгийн төсөв/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	31,012.69	0
3102	Банканд байгаа бэлэн мөнгө /төгрөг/	31,012.69	0
3.1.4.1	Банканд байгаа бэлэн мөнгө /ОНТөсөв/	31,012.69	0
33	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	31,012.69	0
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	31,012.69	0
5103010002	Өмнөх үеийн үр дүн орон нутаг	0	31,012.69
5103020002	Тайлант үеийн үр дүн орон нутаг	31,012.69	-31,012.69
0	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	31,012.69	0
0	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН	31,012.69	0

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	963,660,022.39	962,596,084.33
1303	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	963,592,800.00	962,596,000.00
130302	Орон нутгийн төсвийн санхүүжилтийн орлого	963,592,800.00	962,596,000.00
14	Бараа, үйлчилгээний орлого	67,222.39	84.33
1401021	Орон нутгийн төсвийн хүүгийн орлого	67,222.39	84.33
2603	Төсөвт төвлөрүүлэх	0	2,509,597.02
260302	Төсөвт төвлөрүүлэх орон нутгийн төсөв	0	2,509,597.02
2701+2702	НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ	890,197,450.00	960,117,500.00
2701021300	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн зарцуулалт	118,458,000.00	104,400,000.00
2701023000	ОНО Түшиглэсэн халамжийн үйлчилгээний зарцуулалт	25,914,200.00	50,761,500.00
2702026000	Цаатан иргэдийн мөнгөн тэтгэмж	745,825,250.00	804,956,000.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	890,197,450.00	962,627,097.02
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	73,462,572.39	-31,012.69

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0		0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	0	0
C07	Тайлант үеийн үр дүн	0	0		0



C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	0	0
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	31,012.69	31,012.69
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	0	0
D08	Тайлант үеийн үр дүн	0	0	-31,012.69	-31,012.69
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	0	0

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	963,660,022.39	962,596,084.33
1303	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	963,592,800.00	962,596,000.00
130302	Орон нутгийн төсвийн санхүүжилтийн орлого	963,592,800.00	962,596,000.00
1401	Бараа, үйлчилгээний орлого	67,222.39	84.33
1401021	Орон нутгийн төсвийн хүүгийн орлого	67,222.39	84.33
2701+2702	НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ	890,197,450.00	959,878,920.00
2701021300	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн зарцуулалт	118,458,000.00	104,400,000.00
2701023000	ОНО Түшиглэсэн халамжийн үйлчилгээний зарцуулалт	25,914,200.00	50,761,500.00
2702026000	Цаатан иргэдийн мөнгөн тэтгэмж	745,825,250.00	804,717,420.00
2603	Төсөвт төвлөрүүлэх	73,431,559.70	2,748,177.02
260302	Төсөвт төвлөрүүлэх орон нутгийн төсөв	73,431,559.70	2,748,177.02
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	963,629,009.70	962,627,097.02
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	31,012.69	-31,012.69
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	31,012.69	-31,012.69
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	31,012.69
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	31,012.69	0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Тайлант оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	0	31,012.69	0	0
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0	0	0
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	962,596,000.00	959,878,920.00	2,717,080.00	99.72
УРСГАЛ ЗАРДАЛ	962,596,000.00	959,878,920.00	2,717,080.00	99.72
Халамжийн сан	911,756,000.00	909,117,420.00	2,638,580.00	99.71
Олон нийтийн оролцоонд түншилсэн халамжийн үйлчилгээ	50,840,000.00	50,761,500.00	78,500.00	99.85



ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	962,596,000.00	959,878,920.00	2,717,080.00	99.72
Орон нутгийн төсвөөс санхүүжих	962,596,000.00	959,878,920.00	2,717,080.00	99.72

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаатай холбоотой зөрчил илрээгүй тул төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хүргүүлээгүй болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Мандахнаран, гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Халамж сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Халамжийн сангийн зорилго нь “Төрөөс баримталж буй хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн бодлого зохицуулалтыг нягт уялдуулж, хууль журам, ёс зүйг баримтлан, төрийн үйлчилгээг зорилтот бүлгийн өрх, иргэнд чанартай, шуурхай хүргэнэ” гэсэн байна.

Хөвсгөл аймгийн Халамжийн сан нь улсын төсвийн хөрөнгөөр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. Амьжиргаа дэмжих мөнгөн тусламж
2. Халамжийн бусад хөнгөлөлт үйлчилгээ /цаатан иргэдийн тэтгэмж/
3. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ

Тайлант хугацаанд дээрх тэтгэмж үйлчилгээтэй холбоотой хууль эрх зүйд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын даргын 2018 оны А/174 тоот тушаалаар шинэчлэн баталж, мөрдсөн байна.

Хөвсгөл аймгийн ХХҮГ-ын Захиргаа хяналтын хэлтэс нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны А/515 дугаар захирамжийг баримталж Халамжийн сангийн үйл ажиллагаанд өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

ХХҮЕГ-аас 2021 оны 10 дугаар Хөвсгөл аймгийн Халамжийн сангийн үйл ажиллагаанд хяналт хийж ажилласан байна.



3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл, төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 959.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 19.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 15.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Халамжийн сан нь бараа материал, үндсэн хөрөнгө эзэмшдэггүй бөгөөд тайланд онд авлага, өглөг үүсгэлгүй ажилласан байна. Тайлант мөнгөн хөрөнгө дансанд дараах хөдөлгөөн хийгдсэн байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 0.03 сая төгрөг бөгөөд 0.0 болж 0.03 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь өмнөх онд арилжааны банканд байрших дансны үлдэгдэлд бодогдсон хүүгийн орлого бөгөөд орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Халамжийн сангийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,237.4 сая төгрөгөөр төлөвлөж санал хүргүүлсэн байна.

Төсвийн саналыг Сангийн яам хянаж аймгийн ТЭЗ-аас 2021 оны төсвийг 962.6 сая төгрөгөөр баталсан байна. Хөвсгөл аймгийн Халамж үйлчилгээний газрын 2021 оны батлагдсан төсвийг өмнөх онтой харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 1 /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2021 оны батлагдсан төсөв	2020 оны баталсан төлөвлөгөө	2020 оны гүйцэтгэл	Төлөвлөгөөтэй харьцуулсан дүн	Гүйцэтгэлтэй харьцуулсан дүн
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	962.6	963.4	890.2	-0.8	72.4

Хүснэгтээс харахад: 2021 оны төсвийг өмнөх оны төсвийн төлөвлөлттэй уялдуулан төлөвлөсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл



Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 3 зориулалт арга хэмжээг санхүүжүүлэхээр 962.6 сая төгрөгийн төсөв баталсан ба 100.0 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 962.6 сая төгрөгийн эх үүсвэрийг хүлээн авч, 959.9 сая төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулж, арилжааны банкны хүүгийн орлого 0.03 сая төгрөгийн хамт нийт 2.7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 959.9 сая төгрөг буюу 99.0 хувьтай байна.

Тус байгууллага нь тайлант онд авлага, өр төлбөр үүсгээгүй ба 959.9 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангасан байна.

Хөтөлбөр, арга хэмжээний зардлыг хүснэгтээр харуулав:

Хүснэгт 2 /сая төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
80709	Амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж	106.8	104.4	2.4	97.0
80712	Халамжийн бусад үйлчилгээ /цаатны тэтгэмж/	804.9	804.7	0.2	99.0
80708	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	50.84	50.76	0.08	99.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Хөвсгөл аймгийн Халамжийн сан нь нэмэлт төсвөөр ямар нэг үйл ажиллагаа явуулдаггүй, нэмэлт санхүүжилтийн данс байхгүй.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндэсний статистикийн хорооны даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар хүн амын амьжиргааны доод түвшнийг шинэчлэн баталсан байна. Энэ нь амьжиргааны доод түвшинтэй харьцуулан олгодог халамжийн үйлчилгээний зардал нэмэгдэхэд шууд нөлөөлөх шийдвэр болсон байна.

3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэлийн хүрээнд дотоод хяналт, халамжийн тусламж, үйлчилгээ авдаг иргэдийн жагсаалт, санхүүгийн тайлангийн иж бүрэн байдал болон шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтүүдийг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй зүйл илрээгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2021 онд хугацаа хоцроож оруулсан мэдээлэл байхгүй байна.



3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд өөрчлөлт орсон зүйл байхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн 2 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар онцгойлон үзэх ноцтой асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

4.1 Залруулсан алдаа

Хөвсгөл аймгийн Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар залруулга хийгээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Хөвсгөл аймгийн Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

Хөвсгөл аймгийн Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага тогтоогоогүй болно.

4.4 Зөвлөмж


Хөвсгөл аймгийн Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж хүргүүлээгүй болно.

ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР



[Handwritten signature] А.ЭРДЭНЭБААТАР

[Handwritten signature] Э.БАТ-ЭРДЭНЭ 0/17

[Handwritten signature] Л.МАНДАХНАРАН II/17